9.3 Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Талууд харилцан тохиролцож, бичгээр нэмэлт гэрээ байгуулсны үндсэн дээр шийдвэрлэх бөгөөд Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг зөвхөн бичгээр үйлдэж, Талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

9.4 Энэхүү Гэрээний нэмэлт, өөрчлөлт, хавсралт нь түүний салшгүй хэсэг бөгөөд Гэрээтэй нэгэн адил хууль зүйн хүчин чадалтай байна.

Гүйцэтгэгчийг төлөөлж:
"ЭМ И СИ ЭС ЗЭТ БИ" ХХК-ийн
Гүйцэтгэх Захирал

................................................
/ Б. ЗАЯАТОГТОХ/

Улаанбаатар хот
Сонгинохайрхан дүүрэг, 19-р хороо,
4а, 346 тоот
Утас: 99198295

Захиалагчийг төлөөлж:
"ПЕТРО МАТАД" ХХК-ийн
Гүйцэтгэх захирал

................................................
/ А. ГЭРЭЛТ-ОД /

Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Блю скай цамхаг, 508 тоот.
Утас:70141099, 75751099

6

**Гэрээний Хавсралт №3: Гүйцэтгэгчийн улсын бүртгэлийн гэрчилгээ болон тусгай зөвшөөрөл**


УБ-2

Монгол Улсын Засгийн газрын
2004 оны 20 дугаар тогтоолоор батлав

МОНГОЛ УЛС
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ
0000092593

2015.03.02
/ Бүртгэсэн он сар өдөр /

9011519111
/ Улсын бүртгэлийн дугаар /

5935962
/ Регистрийн дугаар /

Эм И Си Эс Зэт Би — Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Тогтоол — 01 — 2015.02.27
/ шийдвэрийн нэр / — / дугаар / — / он, сар, өдөр /

8299 — Уул уурхайн чиглэлээр зөвлөгөө өгөх
/ код / — / Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

7911 — Аялал жуулчлал
8211 — Бизнесийн зөвлөгөө өгөх
0130 — Цэцэрлэгжүүлэлт

/ код / — / Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй — 2 — 1,000.00
/ хугацаа / — / гишүүдийн тоо / — / өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар Сонгинохайрхан 19-р хороо 4а, 346 тоот, Утас1 91113625, Утас2 99198295, Факс
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Бүртгэлийн газар
/ Бүртгэсэн байгууллагын нэр /

[redacted]

## *Хавсралт 31 Дүйцүүлэн хамгаалах хөтөлбөрийн хүрээнд “”Би Ти Би Өү ХХК – тай байгуулсан ажил гүйцэтгүүлэх гэрээ*

### АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2025 оны 8-р сарын 01-ний өдөр                                        Улаанбаатар хот

Энэхүү Ажил гүйцэтгэх гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-г нэг талаас "Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө 17, Блю скай цамхаг, 5 давхар, 508 тоот" хаягт байрлалтай "Петро Матад " ХХК /РД: 2867095/ (цаашид "Захиалагч" гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал А. Гэрэлт-Од, нөгөө талаас "Дорнод аймаг, Матад сум, 3-р баг, Түмэнхаан 1" хаягт байрлалтай "БТБО" ХХК /РД: 3367371/ (цаашид "Гүйцэтгэгч", хамтад нь "Талууд" гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Х. Ганзориг нар Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйл, үүргийн эрх зүйн нийтлэг зохицуулалт болон холбогдох бусад хууль тогтоомжийг үндэслэн дараах нөхцлөөр харилцан тохиролцож байгуулав.

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү Гэрээний зорилго нь Гүйцэтгэгч нь Захиалагч талын Дорнод аймгийн Матад сумын нутагт дэвсгэрт орших газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ /БХГ/-т "Матад XX" талбайн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд тусгагдсан дүйцүүлэн хамгаалах хөтөлбөрийн хүрээнд Дорнод-Монголын дархан цаазат газруудад тэмдэг, тэмдэглэгээ, нэвтрэх хаалга, хилийн баганыг Гэрээний Хавсралт №1-т заасан Ажлын даалгаврын дагуу хийж гүйцэтгэн суурилуулж, тухайн аймаг, сумын байгаль орчны асуудал эрхэлсэн газруудад хүлээлгэн өгөх /цаашид "Ажил" гэх/, Захиалагч нь Гэрээнд заасан Ажлын хөлсийг төлөх болон эдгээртэй холбоотойгоор Талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлох, тэдгээрийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Гэрээний дагуу хийгдэх Ажлын хэмжээ, тавигдах шаардлага, нөхцөлүүд болон Гүйцэтгэгчийн үнийн санал, улсын бүртгэлийн гэрчилгээ зэргийг доорх хавсралтуудад оруулсан бөгөөд эдгээр нь Гэрээний салшгүй хэсэг болно.
- Хавсралт 1. Ажлын даалгавар
- Хавсралт 2. Гүйцэтгэгчийн үнийн санал
- Хавсралт 3. Гүйцэтгэгчийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар

1.3. Талууд энэхүү Гэрээний дагуу ажиллахдаа Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журам, технологийн горим, стандартууд болон Гэрээний заалтуудыг дагаж мөрдөнө.

### ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

2.1 Гүйцэтгэгч тал нь Гэрээт Ажлыг Захиалагч талтай харилцан тохиролцсон төлөвлөгөөт хуваарийн дагуу Гэрээний 3.4-т заасан урьдчилгаа төлбөрийг хүлээн авснаас хойш хуанлийн 21 хоногт багтаан хийж гүйцэтгэнэ.

2.2 Энэхүү Гэрээ нь Талууд гарын үсэг зурж, баталгаажуулсан өдрөөс хүчин төгөлдөр болж, Талууд Гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлснээр эсвэл Талууд Гэрээг хугацаанаас нь өмнө цуцалснаар дуусгавар болно.

### ГУРАВ. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

3.1 Гэрээт Ажлын нийт хөлс :                    төгрөг байх бөгөөд үүнд НӨАТ орсон болно.

3.2 Хавсралт 2-т заасан үнийн санал зардлын задаргааг тусгасан ба Гэрээнд тусгагдаагүй ажил эсвэл Захиалагчаас тусгайлан бичгээр зөвшөөрөл өгөөгүй аливаа нэмэлт Ажлын зардлыг Захиалагч хариуцахгүй.

8.3.3 Холбогдох хуульд заасан бусад үндэслэл.

8.4 Гэрээг цуцалсан нь Гэрээ зөрчсөний хариуцлагаас Гэрээг зөрчсөн талыг чөлөөлөх үндэслэл болохгүй ба үүнд Гэрээ зөрчсөний торгууль төлөх, нөхөн төлбөр зэрэг хамаарна.

### ЕС. БУСАД ЗҮЙЛ

9.1 Энэхүү Гэрээтэй холбогдон үүссэн аливаа зөрчил, маргааныг Гэрээг байгуулсан эрх бүхий этгээдүүд эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд маргааныг Монгол Улсын хуулийн дагуу харьяаллын шүүхээр шийдвэрлүүлнэ.

9.2 Энэхүү Гэрээ нь Талуудын эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болох бөгөөд Гэрээг хоёр хувь үйлдэн, тал тус бүр нэг хувийг хадгална.

9.3 Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Талууд харилцан тохиролцож, бичгээр нэмэлт гэрээ байгуулсны үндсэн дээр шийдвэрлэх бөгөөд Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг зөвхөн бичгээр үйлдэж, Талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

9.4 Энэхүү Гэрээний нэмэлт, өөрчлөлт, хавсралт нь түүний салшгүй хэсэг бөгөөд Гэрээтэй нэгэн адил хууль зүйн хүчин чадалтай байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

| Гүйцэтгэгчийг төлөөлж: | Захиалагчийг төлөөлж: |
|---|---|
| "БТБО" ХХК-ийн Захирал | "ПЕТРО МАТАД" ХХК-ийн Гүйцэтгэх захирал |
| ............................ | ............................ |
| / Х. ГАНЗОРИГ / | / А. ГЭРЭЛТ-ОД / |
| Дорнод аймаг<br>Матад сум, 3-р баг<br>Түмэнхаан 1<br>Утас: 88117529 | Улаанбаатар хот<br>Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,<br>Blue Sky Tower, 508 тоот.<br>Утас:70141099, 75751099 |

5

*Хавсралт 32 Өрмийн шингэн хаягдлыг Биоремедацийн аргаар нөхөн сэргээх туршилтын танилцуулга*



# Ландфилл-булах арга

Өрмийн хаягдлыг зайлуулах хамгийн түгээмэл аргуудын нэг бөгөөд агааргүй орчин бүрдүүлдэг тул задрах процессийг хязгаарладгаараа хүчилтөрөгчийн солилцоо сайтай ландфарм, ландспрэй аргуудаас ялгаатай.

Ландфиллдэх арга нь газрын тос, давс, биологийн идэвхт метал, усны нөөцийг бохирдуулж болзошгүй. Дэвсгэр геомембраны чанар, нөхөн сэргээлтийн ажлын чанараас шалтгаалан аюултай нэгдлүүд агуулсан хаягдал хөрсөнд нэвчих боломжтой гэж үздэг, тохиромжгүй арга юм.

Энгийн технологи шаарддаг тул эдийн засгийн хувьд ашигтай ч хөрс, гүний усны бохирдол, хог хаягдал хэт их хуримтлагдах сул талтай.



Secure landfill with synthetic liner


Дэвшилтэт аргууд
PETROMATAD
ХУУРАЙ ГАЗРЫН ӨРӨМДЛӨГИЙН ШИНГЭН ХАЯГДАЛ
БИОЛОГИЙН АРГААР БОЛОВСРУУЛАХ
БИОЛОГИЙН БУС АРГААР БОЛОВСРУУЛАХ
БИОРЕМЕДИАЦИ
ЯЛЗМАГ ХИЙХ
ВЕРМИКУЛЬТУР
БИОРЕАКТОРООР ЗАДЛАХ
БУЛАХ
ХАТУУРУУЛАХ
ШАТААХ
ДУЛААНААР ҮЙЛЧЛЭХ
ВАЙБРОСОНИК АРГА

# Өрмийн шингэн хаягдлын сангийн өнөөгийн байдал

PETROMATAD




2024 онд өрөмдсөн

Цэн тогоруу- 2 цооног

(1800 м³: 450 м²:4 м)

Мазаалай – 1 цооног

(1220.4 м³: 305.1 м²: 4 м)

# Ерөнхий мэдээлэл

PETROMATAD

- Петроматад ХХК нь газрын тосны салбарт хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулаад 20 жил болж байна.
- БХГ-т Матад XX талбай нь Дорнод аймгийн Матад суманд оршдог.
- 2024 онд Цэн тогоруу-2, Мазаалай -1 цооногуудыг шинээр өрөмдсөн ба өрмийн шингэн хаягдлын санг нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэхээр бэлтгэж байна.
- Монгол улсад хүлээн зөвшөөрөгдсөн "Өрмийн шингэн хаягдлыг нөхөн сэргээх" MNS 6200:2010 стандарт-д зааснаар хаягдлын санг саармагжуулж, хатууруулан, үл нэвчүүлэх мембранд өлгийдөн, ландфиль аргаар булж, дээр нь ургамал тариалах замаар биологийн нөхөн сэргээлт хийгддэг.
- Ландфиль буюу Булах аргаас гадна дэвшилтэд, байгаль орчинд хохирол багатай аргуудыг дэлхийн улс орнуудад амжилттай хэрэгжүүлж байна.

3

# Төслийн зорилго ба ач холбогдол

PETROMATAD

## Зорилго

- Монголд өрмийн шингэн хаягдлын сангийн бохирдлыг биоремедаци, фиторемедацийн аргаар цэвэрлэж, нөхөн сэргээх

## Зорилт

- Хорт бодис (нефтийн үлдэгдэл, хүнд металл, органик бохирдлын хэмжээ)- ыг 60%-иас дээш задлах.
- Биоаккумулятор буюу хорт бодисыг шингээгч ургамал тариалж, хөрсний шимт чанарыг сэргээх
- БХГ-т МАТАД ХХ талбайд буй Цэн тогоруу-2, Мазаалай 1 цооногуудын шингэн хаягдлын санд биоремедаци, фиторемедацийн туршилт хийж, өргөжүүлэх боломжийг судлах
- Дэвшилтэт технологид суурилсан өрмийн шингэн хаягдлын нөхөн сэргээлтийн стандарт боловсруулах



2

# Цеолитын ач холбогдол

Цеолитийн гол үүрэг нь хүнд металлыг хөдөлгөөнт бус болгож барих, хөрсний нөхцөлийг сайжруулах, микроб ба ургамлын синерги дэмжих замаар хөрсний бохирдлыг багасгах юм.





# Био-нүүрсийн ач холбогдол

PETROMATAD

- ✓ Хөрсийг сийрэгжүүлэх
- ✓ Сэвсгэр гадаргуу нь биоремедацид ашиглах задлагч бичил биетэн үржих таатай нөхцөл бүрдүүлэх
- ✓ Гадаргуун талбайг ихэсгэх
- ✓ Хүнд металлын бохирдлыг татах




14

# Сул болон давуу талууд

PETROMATAD

## Давуу талууд

- Зардал багатай
- Их хэмжээний хаягдлыг био задралд оруулах боломжтой
- Байгальд ээлтэй
- Химийн хатуу нэмэлтүүдийг багасгах
- Өрөмдлөгийн дараа нөлөөлөлд өртсөн газрыг нөхөн сэргээж, дахин ашиглах боломжийг олгож, хөрсийг сайжруулахад хувь нэмэр оруулах боломжтой.

## Сул талууд

- Урт хугацаа шаардана
- Нарийн хяналт, менежмент шаардлагатай
- Тухайн газар нутгийн онцлог хүчин зүйлс /температур, хөрсний найрлага, бичил биетний боломжтой шим тэжээл/ нөлөөлж болно.

## Хязгаарлалтууд

- Биологийн задралын хугацаа

Биоремедаци арга - Технологийн схем



# Биоремедацийн арга

PETROMATAD




Байгальд байдаг бичилбиетийг ашиглаж, органик бодисуудыг задлах арга.

Хаягдал дахь органик бодисыг CO2 , H2O болгон хувиргах процесс юм.

9


Биоремедаци аргын технологийн схем
PETROMATAD
Өрмийн шингэн хаягдал
- Хүнд метал
- Оргиник үлдэгдэл
- Давс
- Тосны үлдэгдлээс бүрдэнэ
Цеолит/ Идэвхжүүлсэн нүүрс
Хүнд метал өөртөө татах/задлах Хөрсний физин/химийн шинж чанар сайжруулах, ургамал ургах нөхцлийг дэмжих
Био шингээгч ургамал
Өрмийн шингэн хаягдалд байх хүнд металийг өөртөө шингээн ургана
Хөрс
Тухайн нөхөн сэргээлт хийх талбайн хөрс
80 хувиас дээш эрүүл хөрс/ Биоаккумуляцид орсон ургамал
8

## Яагаад биоремедацийг сонгох вэ

PETROMATAD

- *Асуудал:* Тамсагийн талбайд газрын тосны үйл ажиллагаа төвлөрч явагддагаас зөвхөн Петро Чайна компани дангаараа 1000 гаруй хайгуул, олборлолт, ус шахалтын цооног өрөмдөж, өрмийн шингэн хаягдлын санг ландфиль аргаар булж, нөхөн сэргээлт хийсэн. Нефтийн үлдэгдэл, хүнд металлын бохирдол нь мембран болон нөхөн сэргээлтийн ажлын чанараас шалтгаалан хөрс, орчныг бохирдуулсаар байна.
- *Шийдэл:* Биоремедаци, фиторемедаци нь байгальд ээлтэй, зардал багатай (уламжлалт аргаас 30-50% хямд), олон улсын туршлагад (Австрали, Канад) амжилттай хэрэгжсэн байдаг.

7

# Баярлалаа



# Тогтвортой хөгжил ба бизнесийн боломж

- Монгол улсын хөгжлийн зорилт, Алсын хараа 2050,
- Шинэ сэргэлтийн бодлого,
- Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого /2018-2027/
- Монгол улсад байгаа газрын тосны зориулалтаар ялгасан 20 гаруй талбайд хаягдлын сан байна. Стандарт нэвтрүүлснээр байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, ногоон хөгжил, орон нутгийн хөгжлийг дэмжих боломжтой
- Оюуны өмч: Биоремедацийн технологийг патентжуулна.
- Өрмийн хаягдлын санг биоремедацийн аргаар нөхөн сэргээх туршилт хийх нь өрмийн хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах бусад боломжийг нэвтрүүлэх суурь судалгаа болно



# Төслийн үр дүн ба нөлөөлөл

PETROMATAD

- Хорт бодисын 60-80% задрал, MNS 5850:2008 стандартад нийцсэн хөрс.
- Нөхөн сэргээсэн талбайд 85%-ийн ургамлын амьдрах чадвар.
- Санхүүжүүлэгч байгууллагын нэр хүнд нийгмийн хариуцлагын өснө, шинэ инноваци, стандарт боловсруулж, нэвтрүүлэхэд чухал алхам болно.






20

# Хүний нөөц ба материаллаг бааз

PETROMATAD

- Петроматад ХХК:
  - Төслийн удирдагч Гэйри Нийл /Петроматад ХХК ХАБЭАБО Менежер/
  - С. Наранжаргал /Петроматад ХХК ХАБЭАБО-ны хэлтсийн орлогч дарга, PhD candidate/,
  - М. Болорчимэг /Петроматад ХХК Байгаль орчны мэргэжилтэн/
  - Э. Амида / Петроматад ХХК Байгаль орчны мэргэжилтэн/
- МУИС Инженер Технологийн Их Сургууль, :
  - Ч.Сономдагва/Төслийн зөвлөх, Профессор
  - Р.Чинзориг /Төслийн зөвлөх, Дэд. Профессор/,
- Грийн трендс ХХК
  - Б. Баяржаргал: / Төслийн зөвлөх, Биоремедацид ашиглах бичил биетний омгуудын судалгаа, бүтээгдэхүүн нийлүүлэлт, хөгжүүлэлт, төслийн зөвлөх, Грийн Трендс ХХК Захирал. КинАкуа бүтээгдэхүүн, /
- БОУАӨЯ, Дорнод аймгийн Байгаль Орчны Газар: Төслийн зөвлөх
- Тоног төхөөрөмж:
  - Лаборатори (МУИС Инженер технологийн Сургуулийн е-Лаб), бусад лаб-д дээж шинжлүүлэх

# Хэрэгжилтийн үе шат ба хугацаа

PETROMATAD

Хугацаа: 2025.09–2028.9 (3 жил)

- Байршил: Матад XX талбай, Дорнод аймгийн Матад сум, Цэн тогоруу 2, Мазаалай 1 цооног
- 1-р шат:(5 сар): бэлтгэл ажил, материал, лаб бэлдэх, Хөрс, усны шинжилгээ, бичил биетний омгийн бэлтгэл, Биоремедиаци, ургамал тариалалтын туршилтыг лабораторын нөхцөлд явуулах
- 2-р шат:(2 жил 2026/04-2028/04):Өрмийн шингэн хаягдлын санд биоремедаци, фиторемидацийн аргаар нөхөн сэргээлтийг хийх
- 3-р шат:(3 жил):(2025/09-2028/09): Мониторинг, тайлагнал, өргөжүүлэлтийн төлөвлөгөө, стандарт боловсруулж батлуулах.

18

# Олон улсын сайн туршлага

PETROMATAD

- Австрали, Канадын амжилтын жишээ
- Австрали (Santos): 2018 онд 200,000 литр хаягдлыг биоремедиациар 95%-ийн үр дүнтэй цэвэрлэсэн.
- Канад (Suncor): 2017 онд 1 сая литр хаягдал шингэнийг дахин боловсруулж, 80%-ийг цэвэр ус болгосон.
- Монголд хэрэглэх боломж: Хуурай уур амьсгал, тал хээрийн онцлогт тохирсон бичил биетний омог ашиглана. /Кинакуа бүтээгдэхүүний туршилт /

17

# Биоаккумулятор ургамлын үүрэг-Фиторемедаци

PETROMATAD

Фиторемедиаци гэдэг нь **ургамлыг ашиглан хөрс, ус, агаараас бохирдуулагчийг цэвэрлэх арга** юм.

Энэ нь экологийн хувьд ээлтэй, харьцангуй бага өртөгтэй тул хүнд металл, нефть, пестицид, органик бохирдуулагч зэрэгт өргөн судлагдаж байна.

МОНГОЛИЙН НӨХЦӨЛД УРГАХ БОЛОМЖТОЙ (HYPERACCUMULATOR) ХҮНД МЕТАЛЛЫГ ХУРИМТЛУУЛАГЧ УРГАМЛУУД

[Нийслэлийн Байгаль Орчны Газар]



## *Хавсралт 33. Байгаль Орчны Аудит 2025 он - Гүйцэтгэгч “Эко Аккюрэси” ХХК-тай байгуулсан ажил гүйцэтгүүлэх гэрээ*

| | |
|---|---|
| **БАТЛАВ:**<br>"ЭКО-АКЮРЭСИ "ХХК-ийн<br>ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ<br>........................ М.ОТГОНЦЭЦЭГ | **БАТЛАВ:**<br>"ПЕТРО МАТАД" ХХК-ийн<br>ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ<br>........................ А.ГЭРЭЛТ-ОД |

**БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

№ [illegible]

2025 оны 8 дугаар сарын 21-ний өдөр Улаанбаатар хот

Энэхүү гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-г нэг талаас "Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6 дугаар хороо, 27-р байр, 11 тоот" хаягт байрлах /Регистрийн дугаар: 5751365/ Байгаль орчны аудитын "Эко-Акюрэси" ХХК (цаашид "Гүйцэтгэгч" гэх)-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Д.Хүрлээ,

Нөгөө талаас "Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайвны өргөн чөлөө, Блю скай цамхаг, 508 тоот" хаягт байрлах "Петроматад" ХХК /Регистрийн дугаар: 2867095/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал А.Гэрэлт-Од (цаашид "Захиалагч", хамтад нь "Талууд" гэх), нар Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйл, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн $10^1$ дугаар зүйлийг удирдлага болгон дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1. Энэхүү Гэрээгээр Гүйцэтгэгч нь Дорнод аймгийн Матад сумын нутагт орших газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ /БХГ/-т "Матад XX" талбайд байгаль орчны аудитын ажил /цаашид "БОА" гэх/-ыг холбогдох хууль тогтоомж, стандарт, аргачлал, журмын дагуу гүйцэтгэж, БОА-ын тайланг боловсруулж Захиалагч талд хүлээлгэн өгөх, Талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлох, Гэрээтэй холбоотойгоор талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Гэрээний дагуу хийгдэх БОА-ын ажлын даалгавар, тавигдах шаардлага, нөхцөлүүд болон Гүйцэтгэгчийн үнийн санал, улсын бүртгэлийн гэрчилгээ зэргийг доорх хавсралтуудад оруулсан бөгөөд эдгээр нь Гэрээний салшгүй хэсэг болно.

- Хавсралт 1. Ажлын даалгавар
- Хавсралт 2. Гүйцэтгэгчийн үнийн санал
- Хавсралт 3. Гүйцэтгэгчийн улсын бүртгэлийн гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн хуулбар

**ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА**

2.1 Гүйцэтгэгч тал нь БОА- ыг Захиалагч талаас ирүүлсэн төлөвлөгөөт хуваарийн дагуу 2025 оны 9 дүгээр сарын 29-ний өдрөөс өмнө хийж гүйцэтгэнэ.

2.2 Энэхүү Гэрээ нь Талууд гарын үсэг зурж, баталгаажуулсан өдрөөс хүчин төгөлдөр болж, Талууд Гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлснээр эсвэл Талууд Гэрээг хугацаанаас нь өмнө цуцалснаар дуусгавар болно.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| | |
|---|---|
| Гүйцэтгэгчийг төлөөлж:<br>"ЭКО-АКЮРЭСИ" ХХК-ийн<br>Гүйцэтгэх захирал<br>........................<br>/ Д. ХҮРЛЭЭ/<br><br>Улаанбаатар хот<br>Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,<br>Бага тойруу, 20, 44 тоот<br>Утас: 99002992, 90482727 | Захиалагчийг төлөөлж:<br>"ПЕТРО МАТАД" ХХК-ийн<br>Гүйцэтгэх захирал<br>........................<br>/ А. ГЭРЭЛТ-ОД/<br><br>Улаанбаатар хот<br>Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,<br>Blue Sky Tower, 508 тоот.<br>Утас:70141099, 75751099 |

## DQE ЦООНОГИЙН ТУРШИЛТ, УС ШАХАЛТ, ХҮЧЛЭЭР УГААХ, ШАВХАЛТ, ПЕРФОРАЦИ, ЦООНОГ ГҮЙЦЭЭЛТИЙН ЯВЦАД

## АСГАРАЛТЫН ҮЕД АВАХ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

**DQE International-ийн Цооногийн Туршилт, Ус Шахалт, Хүчлээр Угаах, Шавхалт, Перфораци, Цооног Гүйцэлтийн төсөлд зориулан боловсруулав.**

| Хянасан | Огноо | Тайлбар | Боловсруулсан | Баталсан |
|---|---|---|---|---|
| 1 | 2022/5/25 | Эх хувь | Лү Лэй | 路雷 |
| 2 | 2024/5/14 | Шинэчилсэн | Лү Лэй | 路雷 |
| 3 | 2025/8/05 | Шинэчилсэн | Lei Changxing | Signature |
| | | | | |
| | | | | |

S

## АГУУЛГА

1-Р БҮЛЭГ: УДИРТГАЛ ..... 4
1.1 Зорилго ба хамрах хүрээ ..... 4
1.2 Эрсдэлд орж болох эх үүсвэр ..... 4
1.3 Эрсдэлийн үнэлгээ ..... 4
1.4 Хариу арга хэмжээний стратеги ..... 6
2-Р БҮЛЭГ: АСГАРАЛТЫГ ИЛРҮҮЛЭХ БА ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ ..... 6
2.1 Хариуцлагын хуваарилалт ..... 6
2.2 Хариу арга хэмжээнүүд ..... 8
2.2.1 Асгаралтыг илрүүлэх ба эх үүсвэрийг удирдах ..... 8
2.2.2 Үнэлгээ ба мэдэгдэл ..... 8
2.2.3 Хяналт ба нөхөн сэргээлт ..... 9
2.2.4 Цэвэрлэсэн бүтээгдэхүүн болон бохирдсон материалыг устгах ..... 9
2.2.5 Цуцлах ..... 9
3-Р БҮЛЭГ: ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЭХ ҮҮСВЭР БА БЭЛТГЭЛ ҮЙЛ АЖИЛЛАГАА ..... 10
3.1 Тоног төхөөрөмж, хангамж, үйлчилгээ ба ажиллах хүч ..... 10
3.2 Сургалтын дасгалууд, журмыг шинэчлэх ..... 11
Хавсралт А Өрөмдлөгийн талбайн төлөвлөгөө ..... 12
Хавсралт Б Яаралтай үед ашиглах утаснууд ..... 13
DQE International-той холбогдох утаснууд ..... 13
Яаралтай тусламж ..... 13
Цэвэрлэгээний байгууллага ..... 13
Хавсралт В Тос асгаралтын үед авах хариу арга хэмжээний схем ..... 14
Хавсралт Г Сургалтын бүртгэл ..... 15

# 1-Р БҮЛЭГ: УДИРТГАЛ

## 1.1 Зорилго ба хамрах хүрээ

Энэхүү тос асгаралтаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний зорилго ("Урьдчилан сэргийлэх төлөвлөгөө") нь хөрс, усан орчинд тос асгарч тархахаас сэргийлэх, хариу арга хэмжээ авах журам тодорхойлоход оршино. Урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг хөрс болон гүний болон ил усан орчинд тос асгарч, аюул учруулсан үед хэрэгжүүлнэ.

Энэхүү урьдчилан сэргийлэх төлөвлөгөөнд заасан журмын зорилт нь тос асгарсан үед олон нийт, DQE-ийн ажилтан болон бусад хариу арга хэмжээ авч буй ажилтнуудыг хамгаалах юм. Мөн тус төлөвлөгөөг байгаль орчин, байгалийн нөөц, барилга байгууламжид тос асгарснаас болж үзүүлэх хор хөнөөлийг багасгах зорилгоор боловсруулсан. Энэхүү урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг DQE-ийн боловсруулсан ХАБЭА-н төлөвлөгөөнд хавсарган урьдчилан сэргийлэх болон хяналтын арга хэмжээний хамт хэрэгжүүлнэ. DQE нь тоног төхөөрөмжөөс асгаралт үүсэхээс сэргийлж нарийвчлан боловсруулсан хяналтын хуудсаар, тогтмол үзлэг/засвар үйлчилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

Энэхүү тос асгаралтаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөнд хариуцлагын хуваарилалт, тос асгарахад авах хариу арга хэмжээ болон түүнийг цэвэрлэх ажиллагаанд баримтлах үндсэн журмыг тодорхойлов.

## 1.2 Эрсдэлд орж болох эх үүсвэр

Цэн тогоруу 2, Цагаан зээр-1, Мазаалай-1 цооногийн талбайтай ойролцоо орших гол нуур, нийтийн хэрэглээнд ашиглах худаг байхгүй.
Цэн тогоруу 2, Цагаан зээр-1, Мазаалай-1 цооногийн талбайтай ойролцоо орших үйлдвэрлэлийн барилга байгууламж, олон нийтийн байгууламж байхгүй. DQE нь иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй тос асгарсан тохиолдолд зохих анхааруулгыг ойролцоох сум, үйлдвэрийн газруудад хүргэж, Дорнод аймгийн онцгой байдлын газар болон Матад сум, Дорнод аймгийн цагдаагийн газартай хамтран ажиллана.

## 1.3 Эрсдэлийн үнэлгээ

Цэн тогоруу 2, Цагаан зээр-1, Мазаалай-1 талбайд DQE-ийн кэмп нь газрын дээр байрласан шатахууны саванд ойролцоогоор 4,920 галлон дизель түлш болон тосоор дүүргэсэн төхөөрөмжид 20 галлон гидравлик шингэн, дизель хөдөлгүүрийн тос хадгалж, ашигладаг. Нэмэлт банкгүй тосон дүүргэлттэй төхөөрөмжийн нийт эзлэхүүн нь ойролцоогоор 20 галлон байдаг. Ихэнх шатахууны савыг нэмэлт танкаар тоноглосон байдаг боловч цооногийн талбайд баримталж буй аюулгүй ажиллагааны дүрэм болон ажлын талбайн зохицуулалтаас хамаарч тосон дүүргэлттэй төхөөрөмжийг нэмэлт танкаар тоноглох боломжгүй.

Хэрэв оргилолт болсон тохиолдолд цооногийн толгойноос газрын тос асгарч болно. Оргилолтын улмаас тос асгарсан тохиолдолд Оргилолтоос Урьдчилан Сэргийлэх Төлөвлөгөөнд заасныг дагана уу.



**Сургалтын Бүртгэлийн хуудас**
**Training - Attendance Sheet**

Компани / Company
Сургалтын нэр / Course Name [redacted] Байгаль орчин.
Байрлал / Location [redacted] Н-2
Огноо / Date(DD-MON-YYYY) [redacted] 2025.09.10
Сургагч багш / Instructor [redacted] Б. Байгал[illegible]
Үргэлжлэх хугацаа (цаг) / Duration (time) [redacted] 40 мин.

*Сургалтанд хамрагдсан нь зөвхөн энэхүү бүртгэлийн хуудсанд гарын үсэг зурснаар баталгаажна. / By Signing this attendance sheet the participant declares

** Хэрэв шаардлагатай бол сургагч багш нь оролцогчийг "COMP" болон "NYC" гэж бичих ёстой. / If required to mark the participant Competent instructor must write "COMP" and for Not Yet Competent "NYC".

| № | Нэр / First Name (Та нэрээ бүтнээр нь тодорхой бичнэ үү.) | Овог / Last Name (Please write your Full name clearly) | Компани / Company | Хэлтэс / Department | Албан тушаал / Position | *Гарын үсэг / Signature | ** Competent / Not Yet Competent |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | [illegible] | | [illegible] | | Менежер | [signature] | |
| 2 | [illegible] | | [illegible] | | [illegible] | [signature] | |
| 3 | [illegible] | | | | [illegible] | [signature] | |
| 4 | [illegible] | | | | [illegible] | [signature] | |
| 5 | [illegible] | | | | [illegible] | [signature] | |
| 6 | [illegible] | | | | [illegible] | [signature] | |
| 7 | [illegible] | | | | [illegible] | [signature] | |
| 8 | [illegible] | | | | HSE | [signature] | |
| 9 | [illegible] | | | | [illegible] | [signature] | |
| 10 | [illegible] | | | | [illegible] | [signature] | |
| 11 | [illegible] | | | | [illegible] | [signature] | |
| 12 | [illegible] | | | | [illegible] | [signature] | |
| 13 | [illegible] | | | | [illegible] | [signature] | |
| 14 | [illegible] | | | | [illegible] | [signature] | |
| 15 | | | | | | | |
| 16 | | | | | | | |
| 17 | | | | | | | |
| 18 | | | | | | | |

[illegible]

Сургагч багшийн гарын үсэг / Instructor's signature [signature]

Огноо / Date (DD-MON-YYYY) 2025.09.10.

***Хавсралт 36 Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагын дагуух “Тербум мод” хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн модны суулгац худалдах худалдан авах гэрээ***

"ПЕТРО МАТАД" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

....................А.ГЭРЭЛТ-ОД

"МЯНДАРТ" ХХК-ИЙН
МЕНЕЖЕР

Ц.МӨНХДЭЛГЭР

**МОДНЫ СУУЛГАЦ ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ**

2025 оны 10 дугээр сарын 13-ны өдөр   Дугаар...   Улаанбаатар

Энэхүү гэрээг нэг талаас "Петроматад" ХХК-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал А.Гэрэлт-Од /цаашид "Худалдан авагч" гэх/, нөгөө талаас "Мяндарт" ХХК-ийн захирал Ш.Оюун /цаашид "Худалдагч" гэх/ нар /цаашид хамтад "талууд" гэх/ Монгол Улсын Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйлийг удирдлага дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав

**НЭГ. ЗОРИЛГО**

1.1. Энэхүү гэрээний зорилго нь энэхүү гэрээний 1.3-т заасан барааг худалдах, худалдан авахтай холбоотойгоор талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хүлээх хариуцлага, энэхүү гэрээтэй холбоотойгоор талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Худалдан авагч нь гэрээний дагуу нийлүүлэх бараа /цаашид "бараа" гэх/ /цаашид "барааны төлбөр" гэх/-ийн үнээр нийлүүлэхээр ирүүлсэн Худалдагчийн үнийн саналыг хүлээн авсан бөгөөд барааг 2025 оны 9 дүгээр сарын 25-ны өдрөөс 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн дотор Худалдан авагчид нийлүүлж, албан ёсны хүлээлцэх баримт бичгээр баталгаажуулна.

1.3 Барааны жагсаалт

| д/д | Барааны нэр | Насжилт | Хэмжих нэгж | Модны өндөр | Тоо хэмжээ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Ягаан сакура | 4 | ширхэг | 80-110 | 70 |
| 2 | Голт бор | 3 | ширхэг | 80-110 | 50 |
| 3 | Агч | 3 | ширхэг | 110-150 | 130 |
| 4 | Цагаан сакура | 4 | ширхэг | 70-100 | 100 |
| 5 | Монос | 4 | ширхэг | 100-120 | 50 |
| 6 | Шинэс, хар мод | 6 | ширхэг | 80-100 | 5 |
| 8 | Нохойн хошуу | 3 | ширхэг | 60-80 | 90 |
| | Дүн | | | | 495 |

**ХОЁР. НИЙТЛЭГ НӨХЦӨЛ**

2.1. Гэрээний 1.2-т заасан хугацаанд Худалдагч нь биет байдлын доголдолгүй /амьд, эрүүл, үндэс нь гэмтээгүй, үндэслэх чадвартай/, эрхийн зөрчилгүй барааг Худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх бөгөөд Худалдан авагч нь хүлээн авсан барааны төлбөрийг Худалдагчид шилжүүлнэ.

2.2. Худалдан авагч нь барааг гэрээний 2.1-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалган хүлээн авч, нийлүүлэлтийн гүйцэтгэлээр барааны төлбөрийг Худалдагчид төлнө.

**ГУРАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА**

3.1 **Худалдагчийн эрх, үүрэг:**

3.1.1. Худалдагч нь энэхүү гэрээнд заасан хугацаанд барааг Худалдан авагчийн заасан байршилд өөрийн зардлаар тээвэрлэн хүргэж Худалдан авагчид нийлүүлэх бөгөөд бараа буюу тухайн модны шинж чанар, суулгацыг тарих, арчлах нөхцөл зэрэг холбогдох мэдээллийг Худалдан авагчид өгнө.

3.1.2. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүй тохиолдолд энэ талаар Худалдан авагчид нэн даруй мэдэгдэж, барааг нийлүүлэх хугацааг Худалдан авагч талтай дахин тохиролцоно.

3.1.3. Худалдан авагч талаас хууль болон энэхүү гэрээнд нийцээгүй нөхцөл, шаардлага тавьсан тохиолдолд түүнийг биелүүлэхээс татгалзах эрхтэй.

3.1.4. Худалдан авагч нь гэрээнд заасан хугацаанд барааны төлбөрийг төлөөгүй тохиолдолд барааг үргэлжлүүлэн нийлүүлэхээс татгалзах эрхтэй.

3.2 **Худалдан авагчийн эрх, үүрэг:**
3.2.1 Худалдагчийн нийлүүлсэн барааг энэхүү гэрээний 2.1-д заасан нөхцөл, чанарын шаардлагад нийцэж байгаа эсэхийг шалгаж хүлээн авах ба төлбөрийг гэрээнд заасны дагуу хугацаанд нь төлөх үүрэгтэй.
3.2.2 Худалдагчийн нийлүүлсэн бараа нь биет байдлын доголдолтой, эсхүл эрхийн зөрчилтэй бол тухайн доголдол, зөрчлийг арилгахыг Худалдагч талаас шаардах, бараа нь гэрээний 2.1-т заасан чанарын шаардлага хангахгүй бол чанарын шаардлага хангасан бараагаар солиулах эрхтэй.
3.2.3 Суулгацыг тарих, арчлах заавар болон бараатай холбоотой мэдээллийг Худалдагчаас авах эрхтэй.
3.2.4 Худалдан авагч нь барааг бүрэн хүлээн авсны дараа барааны төлбөрийг Худалдагчид энэхүү гэрээний 4.1-д заасан дансаар шилжүүлнэ.

3.3 **Талуудын хүлээх хариуцлага**
3.3.1. Худалдагч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлээгүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувиар Худалдагч талд алданги төлнө.
3.3.2. Худалдан авагч нь барааны төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй

бол хугацаа хэтэрсэн хоног тутамд төлөгдөөгүй үнийн дүнгийн 0.1 хувиар Худалдагч талд алданги төлнө.
3.3.3. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөнөөс нөгөө талдаа учруулсан хохирлыг бүрэн хариуцан арилгах үүргэтэй.

## ДӨРӨВ. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

4.1 Талууд энэхүү гэрээнд гарын үсэг зурснаар Худалдан авагч нь Худалдагчийн нэхэмжлэхийн дагуу **ХААН БАНК 5639009207** дансанд барааны төлбөрийн 50 хувийг Худалдагчийн нэхэмжлэхийн дагуу урьдчилан шилжүүлэх бөгөөд урьдчилгаа төлбөрийг Худалдагч хүлээн авснаар барааны захиалга баталгаажина.
4.2 Худалдагч нь гэрээний 2.1-д заасан шаардлагыг хангасан барааг Худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэн хүлээлгэж өгсний дараа Худалдан авагч нь барааны төлбөрийн үлдсэн 50 хувийн төлбөрийг Худалдагч талаас нэхэмжлэх хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор төлнө.
4.3 Худалдагч нь барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлээгүй эсхүл гэрээ цуцлагдсан тохиолдолд урьдчилгаа төлбөрийг Худалдан авагч талд 5 хоногийн дотор буцааж төлнө.

## ТАВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА, СУНГАХ, ДУУСГАВАР БОЛОХ

5.1 Энэхүү гэрээ нь 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдөр хүртэл хугацаанд үйлчилнэ.
5.2 Талууд харилцан тохиролцсоноор гэрээний хугацааг сунгаж болно.
5.3 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлснээр эсхүл гэрээг хуагцаанаас нь өмнө цуцалснаар энэхүү гэрээ дуусгавар болно.

## ЗУРГАА. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

6.1 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйл гэдэгт Гэрээний талууд урьдчилан мэдэх, зайлсхийх, даван туулах боломжгүй бодит нөхцөл байдлыг ойлгох ба үүнд гал түймэр, газар хөдлөл, салхи шуурга, үер, аянга цахилгаан, зуд, гоц халдварт өвчин, тахал зэрэг байгалийн гамшиг, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио цээрийн дэглэм, ажил хаялт, олон нийтийг хамарсан үймээн, самуун, эсэргүүцлийн хөдөлгөөн, террорист халдлага зэрэг талуудын хүсэл зорилгоос үл хамаарах шалтгаануудыг ойлгоно.

6.2 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Талуудын аль нэг нь Гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй эсвэл зохих ёсоор биелүүлээгүй бол нөгөө талдаа ажлын гурав (3) хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.

6.3 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс бий болсон нь хуанлийн нэг сараас дээш хугацаагаар үргэлжилбэл Талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

## ДОЛОО. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛГОХ, ЦУЦЛАХ ҮНДЭСЛЭЛ

7.1 Энэхүү Гэрээ нь Талууд Гэрээний дагуу хүлээсэн үүргээ бүрэн биелүүлснээр эсвэл Талууд Гэрээг хугацаанаас нь өмнө цуцалснаар дуусгавар болно.

7.2 Гэрээг аль нэг талын санаачилгаар хугацаанаас нь өмнө цуцлах бол нөгөө талдаа ажлын тав (5) хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ

7.3 Гэрээг дараах үндэслэлээр цуцална. Үүнд:

а/ Талууд харилцан тохиролцсоноор;

б/ Талуудын аль нэг нь Гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой эсвэл удаа дараа зөрчсөн бол нөгөө талын санаачилгаар. Энэ тохиолдолд аль нэг тал нь Гэрээгээр тохиролцсон аливаа үүргээ биелүүлээгүй, эсвэл Гэрээний дагуу гаргасан баталгаагаа зөрчсөн, эсвэл нөгөө талынхаа өгсөн Гэрээ зөрчсөн тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш арван тав (15) хоногийн дотор залруулах арга хэмжээ аваагүй бол нөгөө тал нь Гэрээ цуцлах тухай мэдэгдлийг бичгээр хүргүүлж Гэрээг цуцлана,

в/ Холбогдох хуульд заасан бусад үндэслэл

7.4 Гэрээг цуцалсан нь Гэрээг зөрчсөн талын хүлээх Гэрээ зөрчсөний хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй ба үүнд Гэрээ зөрчсөний торгууль төлөх, нөхөн төлбөр зэрэг хамаарна.

## НАЙМ. БУСАД ЗҮЙЛ

8.1 Талууд харилцан тохиролцож Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
8.2. Хэрэв Гэрээний хэрэгжилтийн явцад маргаантай асуудал гарвал талууд эвийн журмаар шийдвэрлэх бөгөөд хэрэв тохиролцоонд хүрэхгүй бол холбогдох хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.
8.3 Энэхүү Гэрээ нь Талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
8.4 Энэхүү Гэрээг хууль зүйн хувьд адил хүчинтэй хоёр хувь үйлдсэн бөгөөд талууд тус бүр нэг хувийг хадгална.

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

| | |
|---|---|
| Компанийг төлөөлж: | "Мяндарт" ХХК-г төлөөлж |
| "ПЕТРО МАТАД" ХХК-ийн | "Мяндарт" ХХК-ийн менежер |
| ................ А.ГЭРЭЛТ-ОД | ...... Ц.Мөнхдэлгэр |
| Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг, 1-р хороо Энх тайвны өргөн чөлөө 17, Блю Скай цамхаг, 508 тоот | Хаяг: Монгол Улс, Сүхбаатар аймаг, Түмэнцогт сум, 3-р баг |
| Утас. 976-70141099 | Утас. 976-80039003 |

*Хавсралт 37 Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагын дагуух “Тербум мод” хөтөлбөрийн хүрээнд Матад Сумын Засаг Даргатай хийсэн хамтран ажиллах гэрээ*

## ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2025 оны 10 дугаар сарын 14-ний өдөр Улаанбаатар хот

Энэхүү ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ /цаашид “Гэрээ” гэх/-г нэг талаас 2867095 регистрийн дугаартай “Петро Матад” ХХК /цаашид “Компани” гэх/-ийг төлөөлөн Гүйцэтгэх захирал А.Гэрэлт-Өд, нөгөө талаас Дорнод аймгийн Матад сумын Засаг даргын Тамгын газар (цаашид “ЗДТГ” гэх) нар /цаашид хамтад нь “Талууд” гэх/ дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү Гэрээний зорилго нь Дорнод аймгийн Матад сумын нутаг дэвсгэрт орших газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ /БХГ/-т “Матад ХХ” талбайн батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд Матад сумын нутаг дэвсгэрт нийт 500 ширхэг мод тарих үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх, модны суулгацын судалгаа гаргах, сургалт зохион байгуулах, талбай бэлтгэх болон тарилт хийх зэрэг ажил /цаашид “Ажил” гэх/-ыг гүйцэтгэхтэй холбоотойгоор Талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлох, тэдгээрийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Талууд энэхүү Гэрээний дагуу хамтран ажиллахдаа Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, журам, стандарт болон Гэрээнд заасан нөхцөлүүдийг дагаж мөрдөнө.

### Хоёр. Гэрээний хугацаа

2.1. Энэхүү Гэрээ нь Талууд гарын үсэг зурж, баталгаажуулсан өдрөөс хүчин төгөлдөр болж, 2025 оны 10 дугаар сарын 18-ны өдөр хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.

2.2. Талууд Гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлснээр эсвэл Гэрээг хугацаанаас нь өмнө цуцалснаар энэхүү Гэрээ дуусгавар болно.

### Гурав. Компанийн эрх, үүрэг

3.1. Ажлыг зохион байгуулах, удирдлагаар хангах, Ажлын явц болон гүйцэтгэлд хяналт тавих.

3.2. Компани нь доорх тооны суулгацыг Сүхбаатар Аймгийн Түмэнцогт суманд байрлах “Мяндарт” ХХК-аас худалдан авна.

| д/д | Барааны нэр | Насжилт | Хэмжих нэгж | Модны өндөр | Тоо хэмжээ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Ягаан сакура | 4 | ширхэг | 80-110 | 70 |
| 2 | Голт бор | 3 | ширхэг | 80-110 | 50 |
| 3 | Агч | 3 | ширхэг | 110-150 | 130 |
| 4 | Цагаан сакура | 4 | ширхэг | 70-100 | 100 |
| 5 | Монос | 4 | ширхэг | 100-120 | 50 |
| 6 | Шинэс, хар мод | 6 | ширхэг | 80-100 | 5 |
| 8 | Нохойн хошуу | 3 | ширхэг | 60-80 | 90 |
| | Нийт | | | | 495 |

1

3.3. Ажлын гүйцэтгэлтэй холбоотойгоор ЗДТГ-т санал, хүсэлт гаргах.

3.4. Ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай холбогдох мэдээ, мэдээлэл, зөвлөмж, сургалтаар дэмжлэг үзүүлэх.

3.5. Суулгац, сургалт, сурталчилгааны зардлыг санхүүжүүлэх.

### Дөрөв. ЗДТГ-ын эрх, үүрэг

4.1. ЗДТГ нь Ажлыг хуваарийн дагуу газар дээр нь зохион байгуулах, орон нутгийн иргэд, байгууллагуудыг татан оролцуулах.

4.2. Компаниас томилсон хяналтын ажилтантай хамтран ажиллах, Ажлын явцыг тайлагнах.

4.3. Гүйцэтгэлийн тайлан, фото баримт, тарьсан модны тоо, байршлыг Компанид мэдээлэх.

### Тав. Санхүүжилт ба зардлын хуваарилалт

5.1. Суулгац, сургалт, техникийн зөвлөмжийн зардлыг Компани хариуцна.

### Зургаа. Хариуцлага

6.1. Талууд Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсвэл зохих ёсоор биелүүлээгүй бол учруулсан хохирлыг буруутай тал нөхөн төлнө.

6.2. Хуурамч тайлан гаргах, хөрөнгийн зориулалт зөрчих, хууль бус үйлдэл гаргавал Гэрээг нэн даруй цуцална.

6.3. Үүргээ биелүүлээгүй этгээдэд Монгол Улсын хууль тогтоомжид заасан хариуцлага ногдуулна.

### Долоо. Давагдашгүй хүчин зүйл

7.1. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйл гэдэгт Гэрээний Талууд урьдчилан мэдэх, зайлсхийх, даван туулах боломжгүй, бодит нөхцөл байдлыг ойлгох ба үүнд гал түймэр, газар хөдлөл, хүчтэй салхи шуурга, үер, аянга цахилгаан, зуд, гоц халдварт өвчин, тахал зэрэг байгалийн гамшиг, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио цээрийн дэглэм, ажил хаялт, олон нийтийг хамарсан үймээн, самуун, эсэргүүцлийн хөдөлгөөн зэрэг Талуудын хүсэл зорилгоос үл хамаарах шалтгаануудыг ойлгоно.

7.2. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Талуудын аль нэг нь Гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй эсвэл зохих ёсоор биелүүлээгүй бол нөгөө талдаа нэн даруй мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.

7.3. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс бий болсон нь хуанлийн нэг сараас дээш хугацаагаар үргэлжилбэл Талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

### Найм. Маргаан шийдвэрлэх журам

8.1. Энэхүү Гэрээтэй холбоотойгоор Талуудын хооронд маргаан үүссэн тохиолдолд Талууд маргааныг эвийн журмаар харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

8.2. Тохиролцоонд хүрээгүй бол Талууд маргаанаа шүүхээр шийдвэрлүүлнэ.

### Ес. Бусад зүйл

9.1. Энэхүү Гэрээг хоёр хувь үйлдсэн бөгөөд Талууд тус бүр нэг хувийг хадгална.

2

9.2. Талууд харилцан тохиролцсоноор энэхүү Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд Гэрээний нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж, Талуудын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

9.3. Талууд харилцан тохиролцож Гэрээг цуцалж болох бөгөөд Гэрээний аль нэг тал үүргээ ноцтой зөрчсөн бол нөгөө тал нь 15 хоногийн өмнө бичгээр мэдэгдэж Гэрээг нэг талын шийдвэрээр цуцлах эрхтэй.

9.4. Энэхүү Гэрээг хоёр хувь үйлдэж, Талууд тус бүр нэг хувийг хадгална.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| | |
|---|---|
| Компанийг төлөөлж: | Дорнод аймгийн Матад сумын ЗДТГ-ыг төлөөлж: |
| "ПЕТРО МАТАД "ХХК-ийн ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ | ЗАСАГ ДАРГА |
| ………………… А.ГЭРЭЛТ-ОД | ………………… Э.САРАНХҮҮ |
| Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг, 1-р хороо Энх тайвны өргөн чөлөө 17, Блю скай цамхаг, 508 тоот. | Хаяг: Монгол Улс, Дорнод аймаг Матад сум, 1-р баг, ЗДТГ |
| Утас: 976-70141099 | Утас: 976-88114029 |